**ГАРЧИГ**

1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.......4
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................13
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 22
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................26
5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................27
6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ....................30
7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................31
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................32
9. ДҮГНЭЛТ ....................33

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000297949 дугаартай 8.12 га газрын булангийн цэгүүд ...4
Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ....................13
Хүснэгт 3. Төслийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт .........22
Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ..............................26
Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ......................................27
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт..........................................30
Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....................................................31
Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.............................32

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг ........................................................5
Зураг 2. Төслийн талбайн гадна харагдах байдал фото зураг №1 ...........................................8
Зураг 3. “Тэгри мэд” амралт сувиллын гадна харагдах байдал фото зураг №2 ......................8
Зураг 4. “Тэгри мэд” амралт, сувиллын дотор харагдах байдал фото зураг...........................9
Зураг 5. “Тэгри мэд” амралт сувиллын эмчилгээ, үйлчилгээний өрөөний харагдах байдал ..........................................................................................................................................10
Зураг 6. Эмчилгээ, үйлчилгээ №1 ...........................................................................................11
Зураг 7. Эмчилгээ, үйлчилгээ №2 ...........................................................................................11
Зураг 8. Эмчилгээ, үйлчилгээ №3 ...........................................................................................12
Зураг 9. Эмчилгээ, үйлчилгээ №4 ...........................................................................................12
Зураг 10. “Тэгри мэд” амралт сувиллын газрын барилга байгууламж.................................15
Зураг 11. Төслийн талбайн гадна тохижилт.............................................................................15
Зураг 12. Гадна талбайд явган хүний зам, талбай тохижуулалт ............................................16
Зураг 13. Төслийн талбайн авто зам .........................................................................................17
Зураг 14. Төслийн талбайн явган зам, гэрэлтүүлэг ..................................................................17
Зураг 15. Ус хангамжийн эх үүсвэр эрүүл ахуйн хязгаарлалтын бүс тогтоож хашаалсан байдал ..........................................................................................................................................18
Зураг 16. Бохирын цооног, цэвэрлэх байгууламж.....................................................................18
Зураг 17. Ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулсан...............................................................................................................................19
Зураг 18. Бохирыг тухай бүр соруулсан.....................................................................................19
Зураг 19. Галын аюулгүй байдлын булан...................................................................................20
Зураг 20. Тэгри мэд сувиллын камерын хяналтын өрөө...........................................................20
Зураг 21. Сувиллын ажилчид иж бүрэн хувцасласан зураг ....................................................21
Зураг 22. Гал тогооны ажилчид, зөөгч, үйлчилэгчид иж бүрэн хувцасласан зураг.............21
Зураг 23. Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав ...................................................................28
Зураг 24. Аюултай хог хаягдлын түр хогийн сав ....................................................................29

# 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

***Төслийн нэр :*** “Тэгри мэд” амралт, сувиллын газрын төсөл

***Төслийн зорилго:*** Хүн амд үзүүлэх уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, уламжлалт анагаах ухаан, орчин үеийн анагаах ухаан хосолсон амралт, сувиллын цогцолбор байгуулахад орших юм.

***Ерөнхий мэдээлэл***

*Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:*

- “Хан тэгри мэд” ХХК
- Хувийн хэргийн дугаар: 9011815273
- Регистрийн дугаар: 6531156

*Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:*

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 8-р хороо, 4-р хороолол, 31/1, 18 тоот
- Утас1: 99015970,
- Утас2: 99025049

***Төслийн байршил:***

Төв аймгийн Эрдэнэ сумын, Өгөөмөр 1-р багийн нутагт Улаанбаатар хотоос 56 километрийн зайд Цонжин Болдгийн хөшөөнөөс чанх хойд зүгт 2 километрийн зайд байрлана.

- Талбайн хэмжээ: 8.12 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: M-48-12

***Газарзүйн солбицол***

*Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000297949 дугаартай 8.12 га газрын булангийн цэгүүд*

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | градус | минут | секунд | градус | минут | секунд |
| 1 | 107 | 32 | 15.7 | 47 | 49 | 27.8 |
| 2 | 107 | 32 | 15.5 | 47 | 49 | 28.5 |
| 3 | 107 | 32 | 16.7 | 47 | 49 | 30.3 |
| 4 | 107 | 32 | 15.1 | 47 | 49 | 38 |
| 5 | 107 | 32 | 14.3 | 47 | 49 | 40.1 |
| 6 | 107 | 32 | 12.7 | 47 | 49 | 43 |
| 7 | 107 | 32 | 12.1 | 47 | 49 | 44.5 |
| 8 | 107 | 32 | 13.5 | 47 | 49 | 44.6 |
| 9 | 107 | 32 | 20.2 | 47 | 49 | 45.7 |
| 10 | 107 | 32 | 24.6 | 47 | 49 | 29.8 |




*Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг*

***Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал:***

Тус амралт, сувиллын газар нь нэг ээлждээ 100 хүн, жилд 4500-5500 хүн хүлээн авч, уламжлалт анагаах ухаан, сэргээн засах эмчилгээ үйлчилгээ үзүүлэх орчин үеийн тоног төхөөрөмжтэй холбогдох стандартад нийцсэн клиник сувиллын газар юм.

Үйлчилгээний /амрагчийн/ 43 өрөө, эмчилгээ сувилгааны 10 өрөө, 3 байртай, 2 ээлжийн нийт 70-80 ажилтантай, жилийн дөрвөн улирал тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг.

***Төслийн үндсэн тоног төхөөрөмж, хүчин чадал:***

- Тегри мед сувиллын 3 давхар -1 ш Үүнд:

  Нэг давхарт
  - Хүлээлгийн танхим
  - Ресейпшн
  - Хүлээн авах
  - Харилцагчийн өрөө
  - Үзлэгийн өрөө
  - Монгол үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулах хэсэг
  - Люкс өрөө
  - 2 ортой өрөө
  - 3 ортой өрөө
  - Вип өрөө
  - Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд зориулсан өрөө
  - Кино театр
  - Ресторан

  Хоёр давхарт
  - Хүүхдийн хэсэг
  - Люкс өрөө
  - 2 ортой өрөө
  - 3 ортой өрөө
  - Вип өрөө
  - Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд зориулсан өрөө

  Гурван давхарт
  - Люкс өрөө
  - 2 ортой өрөө
  - 3 ортой өрөө
  - Вип өрөө
  - Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд зориулсан өрөө

  В1 давхарт
  - Оффис
  - Уулзалтын өрөө
  - Үсний Спа үйлчилгээний өрөө
  - Хөвөгч ванны эмчилгээний өрөө
  - Хүүхдийн эмчилгээний өрөө
  - Цөс, бүдүүн гэдэс угаах эмчилгээний өрөө
  - Рашаан заслын эмчилгээний өрөө

  - Уламжлалт эмчилгээний өрөө
  - Бариа заслийн өрөө
  - Массажны өрөө
  - Физик эмчилгээний өрөө
  - Иог, бясалгалын өрөө
  - Ажилчдын өрөө
  - Угаалга, ариутгалын өрөө
- Терасс
- Машины дотор зогсоол
- Сүүдрэвч
- Сагс, волейболын талбай
- Хүүхдийн тоглоомын талбай
- Ногоон байгууламж
- Явган хүний зам
- Машины гадаа зогсоол
- Зам талбайн гэрэлтүүлэг

***Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц:***

- *Усан хангамж:* Унд ахуйн хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн 2 гүний худгаас хангадаг;
- *Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж:* Төвлөрсөн цахилгааны эх үүсвэрээс хангадаг.
- *Бохир ус зайлуулах систем:* Бохир цэвэршүүлэх, хадгалах зориулалт бүхий зөөврийн бохирын системтэй. Герман улсад үйлдвэрлэгдсэн GRAF брэндийн бага оврын цэвэрлэх байгууламжийг 2019 онд угсарсан. Цэвэрлэх байгууламж нь 5 ш танктай, нийт 32,5 тн-ы багтаамжтай. Танкны өндөр нь 2.1 м, урт нь 2.39 м, өргөн нь 2.19 м хэмжээтэй. Өдөрт 13.5 тн бохир усыг 98% хүртэл цэвэршүүлэн хөрсөнд шингээнэ. Тус амралтын газрын шингээлтийн талбайд нийт 90 ш шингээлтийн туннел угсрагдсан бөгөөд туннелийн цэвэрлэгдсэн ус хуримтлуулах багтаамж нь 27 тн байна.
- *Харилцаа холбоо:* Үүрэн холбооны операторууд болох Mobicom, Skytel, Unitel, G-mobile операторуудын сүлжээгээр холбоо барих бүрэн боломжтой;



*Зураг 2. Төслийн талбайн гадна харагдах байдал фото зураг №1*



*Зураг 3. "Тэгри мэд" амралт сувиллын гадна харагдах байдал фото зураг №2*




*Зураг 4. "Тэгри мэд" амралт, сувиллын дотор харагдах байдал фото зураг*



*Зураг 5. "Тэгри мэд" амралт сувиллын эмчилгээ, үйлчилгээний өрөөний харагдах байдал*

***<u>Эмчилгээ, үйлчилгээ</u>***




*Зураг 6. Эмчилгээ, үйлчилгээ №1*




*Зураг 7. Эмчилгээ, үйлчилгээ №2*




*Зураг 8. Эмчилгээ, үйлчилгээ №3*




*Зураг 9. Эмчилгээ, үйлчилгээ №4*

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | |
| 1 | Агаарын бохирдол үүсэх | Ил задгай хог хаягдал шатаахгүй байх | Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг төслийн талбайд байрлах хог хаягдлын түр цэгт цуглуулан, гэрээний дагуу зайлуулдаг. | Дотоод зардал | |
| 2 | | Орчны тоосжилт үүсгэхгүй байхад анхаарч, ил гарсан элэгдэлд орсон хөрсийг зүлэгжүүлэх | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зүлэгжүүлэлт хийж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн. | Үйл ажиллагааны зардал | |
| 3 | | Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хийх | | | |
| Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | |
| 1 | Усан орчин бохирдох,<br><br>Усны нөөц хомсдох | Ногоон байгууламжийн усалгаанд ашиглахаар борооны ус цуглуулах, нөөцлөх бичил байгууламжтай болох | Борооны усыг хуримтлуулан ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| 2 | | Ус бохирдуулсны төлбөр төлөх | Ус бохирдуулсны төлбөрийг төлсөн. | Дотоод зардал | |
| 3 | | Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/ | Ариун цэврийн байгууламжийг сайжруулан, ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 4 | | Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах | Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| 5 | | Ус ашиглагч нь бохирын цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ. | Бохир ус зайлуулах цооног дүүрэх үед тухай бүр суллаж, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэж байсан. | Үйл ажиллагааны зардал | |
| Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | |
| 1 | Хөрсний бохирдол | Төслийг хэрэгжүүлэх явцад төслийн талбай болон түүний ойр орчимд олон салаа зам гаргаж, хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах, бохирдуулахаас урьдчилан сэргийлж, зам талбайн тэмдэгжүүлэлтийг зохих дүрэм журмын дагуу хийж, хаалт хамгаалалт хийх | Төслийн талбай болон түүний ойр орчимд ажилчид болон амрагчдад зориулан зам талбайн тэмдэгжүүлэлтийг байршуулсан. | Үйл ажиллагааны зардал | |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2 | | Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах | Гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийж, орчны тохижилтыг сайжруулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. | Үйл ажиллагааны зардал | |
| 3 | | Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх | Төслийн талбайн хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт хаяж гэрээний дагуу тогтмол зайлуулж байсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 4 | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хаягдлыг дахин боловсруулдаг байгууллагуудад хүлээлгэн өгч, хамтран ажиллах | Төслийн үйл ажиллагаанаас гарсан дахин боловсруулах дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулдаг байгууллагатай хамтран ажиллахаар гэрээ байгуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 5 | | Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах | Төслийн хог хаягдлыг орон нутагтай хийсэн гэрээний дагуу тогтмол зайлуулдаг. | | |
| 6 | | Төв замаас тухайн эдэлбэр газар хүртэл нэг замтай байх ба замын дагуу (500-1000) м-ийн зайд MNS 4596:2014, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм стандартын дагуу цогцолбор хаяг бүхий замын тэмдгийг байршуулах. | Төв замаас төслийн талбай хүртэлх замын дагуу тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | |
| 1 | Ургамал | Амралтын газрын үйл ажиллагааг илэрхийлсэн нэр хаяг бүхий самбар, ногоон байгууламж, явган хүний зам, олон нийтийн амралт, тоглоомын талбай, тээврийн зогсоол зэрэг нь тэмдэг тэмдэглэгээтэй байна. | Ногоон байгууламж, явган хүний зам, олон нийтийн амралт, тоглоомын талбай, тээврийн зогсоолд тэмдэг тэмдэглэгээтэй байршуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| Эрчим хүч | | | | | |
| 1 | Цахилгаан эрчим хүчний хэрэглээ | Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх | Гадаа талбайн гэрэлтүүлэгт нарны гэрлээр цэнэглэгддэг гэрэл суурилуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 2 | | Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх | Амралт сувиллын барилга дотор болон гадна талбайд лед гэрэл байршуулсан. Барилгын дотор үүдний хэсгүүдэд хөдөлгөөн мэдрэгчтэй гэрэл суурилуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 3 | | Ариун цэврийн газар нь агааржуулагч сэнстэй байна. | Амралтын газрын ариун цэврийн өрөөнүүд нь бүгд агааржуулалтын системтэй. | Үйл ажиллагааны зардал | |
| 4 | | Зочны аюулгүй байдлыг хангах үүднээс гар чийдэнгийн нөөцтэй байна | Гэнэтийн нөхцөл байдлын үед амрагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс гар чийдэн худалдан авсан. | Үйл ажиллагааны зардал | |
| **Нийт дүн** | | | | - | - |

**Газрын гадарга, хөрсөн орчныг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**



*Зураг 10. "Тэгри мэд" амралт сувиллын газрын барилга байгууламж*





*Зураг 11. Төслийн талбайн гадна тохижилт*

"Тэгри мэд" амралт сувиллын барилга байгууламжийн гадна талбайг тохижуулж явган хүний зам, гэрэлтүүлэг хийж, ногоон байгууламж байгуулсан.

Хөрс, газрын гадарга, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд Тээврийн хэрэгслийн зогсоолыг MNS 5342:2007 "Авто машины зогсоол ангилал, ерөнхий шаардлага"-ын дагуу тохижуулсан,явган хүний замыг явган замын хавтан болон, хатуу хучилттай болгож нэмэгдүүлж арчилгаа, тохижилтыг хийсэн, чиглэл заасан, хориглосон тэмдэг, тэмдэглэгээ байршуулж бусад сул талбайн ногоон байгууламжийг хамгаалах хаалт хашлага хийсэн.



*Зураг 12. Гадна талбайд явган хүний зам, талбай тохижуулалт*



*Зураг 13. Төслийн талбайн авто зам*



*Зураг 14. Төслийн талбайн явган зам, гэрэлтүүлэг*

***Усан орчин бохирдох, усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ***



*Зураг 15. Ус хангамжийн эх үүсвэр эрүүл ахуйн хязгаарлалтын бүс тогтоож хашаалсан байдал*



*Зураг 16. Бохирын цооног, цэвэрлэх байгууламж*



*Зураг 17. Ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулсан*



*Зураг 18. Бохирыг тухай бүр соруулсан*

**Хөдөлмөр, аюулгүй ажиллагааны зардал**

Галын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд галын тэмдэг, тэмдэглэгээ худалдан авч, галын буланг хийсэн.




*Зураг 19. Галын аюулгүй байдлын булан*



*Зураг 20. Тэгри мэд сувиллын камерын хяналтын өрөө*

Ажилчид болон амрагч сувилуулагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс иж бүрэн гадна талбай болон барилгыг камержуулсан бөгөөд аливаа байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, зөрчлийг илрүүлэх хяналтыг сайжруулахад мөн өндөр үр дүнтэй юм.

Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангасан.



*Зураг 21. Сувиллын ажилчид иж бүрэн хувцасласан зураг*



*Зураг 22. Гал тогооны ажилчид, зөөгч, үйлчлэгчид иж бүрэн хувцасласан зураг*

Хөдөлмөр, аюулгүй ажиллагааны ажлын хүрээнд 2023 онд 485,850 төгрөг зарцуулсан /баримтыг хавсралт-1 хавсаргав/.

## 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 3. Төслийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт*

| № | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Ногоон байгууламж бий болгох | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд төслийн талбайд шилмүүст мод, гоёлын бут сөөг тарьсан. Ногоон байгууламжийн усалгаа дуслын усалгааны систем, зүлэг услах бороожуулагчийг байршуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| | Хөрс бэлтгэх<br>Нүх бэлтгэх | Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэсэн. | Дотоод зардал | |

Хан Тэгри Мэд ХХК нь төслийн талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламж байгуулан агро арчилгааг ургамал ургалтын эрчимтэй хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Үүнд: Зүлэгжүүлсэн талбайн өвөлжилт болон хаврын сэргэн ургалтын байдлыг аж ахуйн албаны дарга Жамсрантай хамтран хийж 2023 оны ургамал ургалтын хугацаанд зүлэгжүүлсэн талбай, модонд усалгаа арчилгааг төлөвлөж хийж гүйцэтгэсэн дуусав. Төлөвлөгөөний дагуу контенейрыг хааж шинээр 130 см-ээс 180 см өндөртэй хайлаас, голтбор, шар хуайс болон нохойн хошуу тарьсан. Усалгааны системийг нэмэгдүүлж шинэ тарьсан моднуудад дуслын усалгаа зүлэгт талбайд 35 ширхэг бороожуулагчийг нэмж байршуулсан. 2022 онд малд идэгдэж хорогдсон гүйлс, буйлсыг нөхөн тарьсан. Зүлэгт талбайн зүлгийг 2023 оны 07 дугаар сарын 22-ны өдөр хадах, услах, зүлэгт талбайн хог ургамлыг түүх, 2022 оны тарилтуудад нөхөн тарилт хийж, тармуураар сийрүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэв. Терарумын ургамлыг арчилж услах зөвлөгөө өгч ажилласан.

Арчилгааны ажлыг зургаар баталгаажуулсан болно.

Зүлэг, модны өвөлжилтийн дараах байдал:




Зүлэг хадаж, нөхөн тарьж, модонд дуслын усалгаа суурилуулав.





# 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нийт зардал |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Археологийн болон Палеонтологийн дурсгал | Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой. | Төслийн талбайд соёлын биет өв илрээгүй болно. | - |
| **Нийт дүн** | | | | - |

# 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Хог хаягдлын ангилал | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | | |
| 1 | Ахуйн хог хаягдал | Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах | Хог хаягдлын цэгийг ангилах ялгах байдлаар тохижуулан ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах | Хог хаягдлыг ангилан ялгаж хаях хогийн савыг байрлуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг “MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлд. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлэх. | Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу мэргэжлийн газраар хийлгэсэн. /Баримтыг хавсаргав/ | 6.820.000 | |
| | | Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлах. | MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлан ажилладаг. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хог устгалын цэгт хүргэх | Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, орон нутагтай байгуулсан гэрээний дагуу устгалын цэгт хүргүүлж устгуулдаг. | Сар бүр 30,000 | |
| | | Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах | | | |
| | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаан 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| 2 | Аюултай хог хаягдал | Төслийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлэх | Сувиллын үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлдэг. /гэрээг хавсаргав/ | Сард 65,000 | |
| **Нийт дүн** | | | | | |

***Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ***

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний ажлын хүрээнд сумын ТҮК-тэй гэрээ байгуулж, гэрээний дагуу тогтмол зайлуулж байсан.

2023 онд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардалд 10,436,300 төгрөг зарцуулсан /мөнгөн зардлын баримтыг хавсаргав/.




*Зураг 23. Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав*




*Зураг 24. Аюултай хог хаягдлын түр хогийн сав*

# 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

*Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэг байршил | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Хөрсөн бүрхэвч | | | | | |
| 1 | Хөрсний агрохими, хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr) | - Төслийн талбай-1 цэг | Хөрсний агрохими, хүнд металлын дээжийг 200-300 гр хэмжээтэй авч “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 50,000.0 | 50,000.0 |
| Усны чанар | | | | | |
| 3 | Ерөнхий химииз | - Гүний худгийн ус-1 цэг<br>- Цэвэрлэх байгууламжийн оролтын ус- 1 цэг<br>- Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус - 1цэг | Унд, ахуйн хэрэглээний уснаас нэг усны сорьц авч “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 135,000.0 | 135,000.0 |
| **Нийт дүн** | | | | | **185,000.0** |

# 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | 2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөсөн ажлууд | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт** |
|---|---|---|
| 1 | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | "Хан тэгри мэд" ХХК нь Төв аймгийн Эрдэнэ сумын засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан, сум орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтыг дэмжих зорилгоор 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. /хамтран ажиллах гэрээг хавсаргав/ |
| 2 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОАЖЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх | БОМТ болон биелэлтийн тайланг хариуцах мэргэжилтэн томилж, хуульд заасан хугацаанд өгч ажиллаж байна. |
| 3 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг тайлан хийлгүүлэхээр газрын мэргэжлийн байгууллагатай гэрээ хийсэн. |
| **Нийт дүн** | | **5,000,000** |

# 8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт*

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1 | Төв аймгийн БОАЖГ-т БОМТ-ний биелэлтийг тайлагнах | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл хэлбэрээр 2023 оны 11-р сарын 01-ны өдөр хүргүүлсэн. |
| 2 | БОАЖЯ тухайн жилийн БОМТ батлуулах | Тухайн жилийн БОМТ-өөг БОАЖЯ-ны сайтад онлайн хэлбэрээр байршуулсан. |
| **Нийт дүн** | | - |

# 9. ДҮГНЭЛТ

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах "Хан тэгри мэд" ХХК-ийн "Тэгри мэд" нэртэй амралт, сувиллын төслийн 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 – ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- "Хан тэгри мэд" ХХК нь 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт 18,016,800.0 төгрөг зарцуулсан байна;

Хавсралт 1- Хөдөлмөр, аюулгүй ажиллагааны зардал

| Д/д | Огноо | Харьцсан данс | Гүйлгээний утга | Дебет | Кредит |
|---|---|---|---|---|---|
| Данс: | 6101-00-11 | | Сув-Хөдөлмөр, аюулгүй ажиллагааны зардал | | |
| | | | Эхний үлдэгдэл: | | |
| 1 | 2021/01/21 | 1101-00-01 | Зай барь тэмдэг 20 ш,Золхүү | 46,500.00 | 0.00 |
| 2 | 2021/02/08 | 1101-00-01 | Галын тэмдэг,тэмдэглэгээ /88002560/ | 137,500.00 | 0.00 |
| 3 | 2021/02/25 | 1101-00-01 | Галын тэмдэг-13 ш , Лед гэрэл , кроп | 66,000.00 | 0.00 |
| 4 | 2021/02/28 | 1401-00-01 | 2021/2-р сарын хангамжийн материалын зарцуулалт | 5,850.00 | 0.00 |
| 5 | 2021/12/27 | 1101-00-15 | ЕВ -Хан Тэгри Мэд ХХК Одбат эрүүл мэндийн хуудас | 20,000.00 | 0.00 |
| 6 | 2022/03/18 | 1101-00-15 | Цагаан дэвтэр шинжилгээний үнэ | 20,000.00 | 0.00 |
| 7 | 2022/03/25 | 1101-00-15 | Эрүүл мэндийн цагаан дэвтэр Одмаа | 20,000.00 | 0.00 |
| 8 | 2022/03/25 | 1101-00-15 | Цагаан дэвтэр Намуунбайгал | 20,000.00 | 0.00 |
| 9 | 2022/05/31 | 1101-00-15 | ЕВ -Хан Тэгри Мэд ХХК-6531156 лифт техник магдлал | 150,000.00 | 0.00 |
| Дт - 9 | | Кт - 0 | Нийт - 9 ДҮН: | 485,850.00 | 0.00 |

Хавсралт 2- Энгийн болон эмнэлгийн хог хаягдлын зардал

| Д/д | Огноо | Харьцсан данс | Гүйлгээний утга | Дебет | Кредит |
|---|---|---|---|---|---|
| Данс: | 1414-00-23 | | Рес-Хог хаягдлын зардал | | |
| | | | Эхний үлдэгдэл: | | |
| 1 | 2023/01/31 | 1415-00-01 | 01 сарын дуусаагүй үйлдвэрлэлийн өртгийг ресторанын өртөгт шингээв: | 0.00 | 396,000.00 |
| 2 | 2023/02/13 | 3101-00-01 | 02/13-ны хог түрэлт | 132,000.00 | 0.00 |
| 3 | 2023/02/28 | 1415-00-01 | 02 сарын дуусаагүй үйлдвэрлэл дансыг нэгтэв. | 0.00 | 264,000.00 |
| 4 | 2023/03/16 | 3101-00-01 | Хог түрэлт 3.16 | 132,000.00 | 0.00 |
| 5 | 2023/03/31 | 3101-00-01 | 03/31-ны хог түрэлт | 132,000.00 | 0.00 |
| 6 | 2023/03/31 | 1415-00-01 | 03 сарын Ресторанын бараа материал Дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэв. | 0.00 | 264,000.00 |
| 7 | 2023/04/17 | 3101-00-01 | 04/17 Хог түрэлт | 132,000.00 | 0.00 |
| 8 | 2023/04/30 | 1415-00-01 | 04 сарын дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэв. | 0.00 | 132,000.00 |
| 9 | 2023/05/05 | 3101-00-01 | 05.05. Хог хүргэлт | 26,400.00 | 0.00 |
| 10 | 2023/05/22 | 3101-00-01 | 2023/05/22 Хог түрэлт | 132,000.00 | 0.00 |
| 11 | 2023/05/29 | 1101-00-03 | 2230502625701;10200866122;6531156;10200866122;8888 /Хогны төлбөр/ | 216,000.00 | 0.00 |
| 12 | 2023/05/31 | 1415-00-01 | 05 сарын дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэв. | 0.00 | 374,400.00 |
| 13 | 2023/06/13 | 3101-00-01 | 06/13 Хог түрэлт | 132,000.00 | 0.00 |
| 14 | 2023/06/27 | 3101-00-01 | Хог ачилтын зардал | 26,400.00 | 0.00 |
| 15 | 2023/06/30 | 1415-00-01 | 06 сарын дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэв. | 0.00 | 132,000.00 |
| 16 | 2023/07/17 | 3101-00-01 | 07.21. Хог тээвэрлэлт | 132,000.00 | 0.00 |
| 17 | 2023/07/27 | 3101-00-01 | 07.27. Хог тээвэрлэлт | 26,400.00 | 0.00 |
| 18 | 2023/07/31 | 1415-00-01 | 07 сарын дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэв. | 0.00 | 158,400.00 |
| 19 | 2023/08/07 | 3101-00-01 | 08.07. Хог тээвэрлэлт | 26,400.00 | 0.00 |
| 20 | 2023/08/17 | 3101-00-01 | 08.17. Хог тээвэрлэлт | 26,400.00 | 0.00 |
| 21 | 2023/09/09 | 3101-00-01 | 09/09 Хог тээвэрлэлт | 26,400.00 | 0.00 |
| 22 | 2023/09/25 | 3101-00-01 | 09.25. Хог тээвэрлэлт | 26,400.00 | 0.00 |
| Дт - 15 | | Кт - 7 | Нийт - 22 ДҮН: | 1,324,800.00 | 1,720,800.00 |

| Д/д | Огноо | Харьцсан данс | Гүйлгээний утга | Дебет | Кредит |
|---|---|---|---|---|---|
| Данс: | 6101-00-20 | | Сув-Эмнэлэгийн болон энгийн хог хаягдлын зардал | | |
| | | | | Эхний үлдэгдэл: | |
| 1 | 2023/01/31 | 6103-00-19 | 2023/01 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 23,166.13 |
| 2 | 2023/03/10 | 3101-00-01 | 2022 оны 4 улирал, 2023 оны 1 улиралын Тусгай хог хаягдал төлбөр | 390,000.00 | 0.00 |
| 3 | 2023/03/16 | 3101-00-01 | Хог түрэлт 3.16 | 88,000.00 | 0.00 |
| 4 | 2023/03/31 | 3101-00-01 | 03/31-ны хог түрэлт | 88,000.00 | 0.00 |
| 5 | 2023/03/31 | 6103-00-31 | 2023/03 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 50,940.00 |
| 6 | 2023/04/01 | 3101-00-01 | 2023/04 сар тусгай хог хаягдалын төлбөр | 65,000.00 | 0.00 |
| 7 | 2023/04/17 | 3101-00-01 | 04/17 Хог түрэлт | 88,000.00 | 0.00 |
| 8 | 2023/04/30 | 6103-00-31 | 2023/04 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 11,265.78 |
| 9 | 2023/05/01 | 3101-00-01 | 2023/05 сар тусгай хог хаягдалын төлбөр | 65,000.00 | 0.00 |
| 10 | 2023/05/05 | 3101-00-01 | 05.05. Хог хүргэлт | 193,600.00 | 0.00 |
| 11 | 2023/05/22 | 3101-00-01 | 2023/05/22 Хог түрэлт | 88,000.00 | 0.00 |
| 12 | 2023/05/29 | 1101-00-03 | 2230502625701;10200866122;6531156;10200866122;8888 /Хогны төлбөр/ | 144,000.00 | 0.00 |
| 13 | 2023/05/31 | 6103-00-31 | 2023/05 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 83,402.00 |
| 14 | 2023/06/01 | 3101-00-01 | 2023/06 сар тусгай хог хаягдалын төлбөр | 65,000.00 | 0.00 |
| 15 | 2023/06/13 | 3101-00-01 | 06/13 Хог түрэлт | 88,000.00 | 0.00 |
| 16 | 2023/06/27 | 3101-00-01 | Хог ачилтын зардал | 193,600.00 | 0.00 |
| 17 | 2023/06/30 | 6103-00-27 | 2023/06 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 24,480.00 |
| 18 | 2023/07/01 | 3101-00-01 | 2023/07 сар тусгай хог хаягдалын төлбөр | 65,000.00 | 0.00 |
| 19 | 2023/07/17 | 3101-00-01 | 07.21. Хог тээвэрлэлт | 88,000.00 | 0.00 |
| 20 | 2023/07/27 | 3101-00-01 | 07.27. Хог тээвэрлэлт | 193,600.00 | 0.00 |
| 21 | 2023/07/31 | 6103-00-31 | 2023/07 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 48,524.00 |
| 22 | 2023/08/31 | 1501-00-20 | Эмнэлэгийн хог хаягдал-2023/8 | 65,000.00 | 0.00 |
| 23 | 2023/09/25 | 3101-00-01 | 09.25. Хог тээвэрлэлт | 193,600.00 | 0.00 |
| 24 | 2023/09/30 | 1501-00-20 | Эмнэлэгийн хог хаягдал-2023/9 | 65,000.00 | 0.00 |
| 25 | 2023/10/01 | 3101-00-01 | 2023/10 сар тусгай хог хаягдалын төлбөр | 65,000.00 | 0.00 |
| Дт - 19 | | Кт - 6 | Нийт - 25 ДҮН: | 2,291,400.00 | 241,777.91 |

Хавсралт 3- Ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардал

| Д/д | Огноо | Харьцсан данс | Гүйлгээний утга | Дебет | Кредит |
|---|---|---|---|---|---|
| Данс: 6101-00-19 | | | Сув-Ариутгал, халдваргүйжилтийн зардал | | |
| | | | | Эхний үлдэгдэл: | |
| 1 | 2023/05/12 | 1101-00-03 | 6531156-АРИУТГАЛ ХИЙЛГЭСЭН 5.11,ЭНХТӨР М | 3,200,000.00 | 0.00 |
| 2 | 2023/05/31 | 6103-00-26 | 2023/05 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 99,134.46 |
| 3 | 2023/05/31 | 6103-00-27 | 2023/05 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 4,862.00 |
| 4 | 2023/05/31 | 6103-00-28 | 2023/05 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 7,480.00 |
| 5 | 2023/05/31 | 6103-00-29 | 2023/05 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 137,166.20 |
| 6 | 2023/05/31 | 6103-00-31 | 2023/05 сарын сувиллаас амралтын өртөг хуваарилав | 0.00 | 295,357.34 |
| 7 | 2023/08/17 | 1411-00-01 | Сувьлагчийн пост | 12,564.49 | 0.00 |
| 8 | 2023/08/24 | 1411-00-01 | Сувьлагчин пост | 7,538.70 | 0.00 |
| 9 | 2023/09/05 | 1101-00-03 | 6531156 - АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ 08.31 | 3,600,000.00 | 0.00 |
| Дт - 4 | | Кт - 5 | Нийт - 9 ДҮН: | 6,820,103.19 | 544,000.00 |

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

**НЭХЭМЖЛЭХ № 112.**

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр: Эко Эрдэнэ
Хаяг: ХУД 17-р хороо Маршал Таун 1-17
Утас: Факс: 99077906
Э_шуудан
Банкны нэр Хаан банк Мөнхсайхан
Банкны дансны дугаар 5085209532
Регистрийн №:

Төлөгч:
Байгууллагын нэр: Хан Тэгри Мэд ХХК
Хаяг: Төв аймаг Эрдэнэ сум Өглөөмөр 1-р баг
Гэрээний № 97
Нэхэмжилсэн огноо 2023.08.31
Төлбөр хийх хугацаа 2023.09.05

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| | Ариутгал Халдваргүйтгэл | 4000 | 900 | 3,600,000 |
| | | | Дүн | |
| | | | НӨАТ | |
| | | | Нийт дүн | 3,600,000 |

Мөнгөний дүн Гурван сая зургаан зуун мянган (үсгээр) төгрөг болно.

Дарга Э. Мөнхсайхан /............/
(Тамга) Хүлээн авсан ............/............/
Нягтлан бодогч ............/............/

Хавсралт 4- Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал

| Д/д | Огноо | Харьцсан данс | Гүйлгээний утга | | Дебет | Кредит |
|---|---|---|---|---|---|---|
| Данс: | 6101-00-09 | | Сув-Засвар үйлчилгээний зардал | | | |
| | | | | | Эхний үлдэгдэл: | |
| 1 | 2023/10/31 | 1101-00-03 | Бонго сэлбэг хэрэгсэл авав. | | 1,910,000.00 | 0.00 |
| Дт - 1 | | Кт - 0 | Нийт - 1 | ДҮН: | 1,910,000.00 | 0.00 |

Хавсралт 5- Ус бохирдуулсны төлбөрийн баримт



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 3230502630031

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 10200866122 / 6531156 |
| Татвар төлөгчийн нэр: | Хан тэгри мэд |
| Татварын төрөл: | 01030722 - Ус бохирдуулсны төлбөр |
| Харъяалах татварын алба: | Төв / Аймгийн төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 651,900.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2023-05-29 13:28:18.0 |
| Гүйлгээний утга: | 3230502630031;;6531156;;;88885049;3005137242;ХАН ТЭГРИ;Golomtbank-Online;888 |
| Татварын данс: | ТЕГ.Ус бохирдуулсны төлбөр - 100900000417 |
| Төлөлтийн хэлбэр: | Голомт банк |

Хавсралт 6- Хог хаягдлын гэрээ

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА А.МӨНГӨНБАЯР

**ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭСНИЙ ТӨЛБӨР ТӨЛӨХ ГЭРЭЭ**

2023.05.19 № 37 Эрдэнэ-Уул

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.4.2 дахь заалтыг үндэслэн Засаг даргын Тамгын газрыг төлөөлж Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн **Ц.Ганбаяр,** хог үүсгэгчийг төлөөлж нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Төв аймгийн Эрдэнэ сум, Өгөөмөр 1 дүгээр баг Баяндаваны адагт байрлах 9011815273 улсын бүртгэлийн дугаар, 6531156 регистрийн дугаартай "Хан тэгри мэд" ХХК-ны хүний нөөцийн менежер Ж.Аянагүл нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Хог үүсгэгчийн үүрэг:**

1.1.Тогтоосон чиглэлийн дагуу хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэх

1.2. Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааг ханган тээвэрлэх

1.3. Хог хаягдлын төлбөр хураамжийг сар бүр төлөх

Сумын ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолын дагуу **хог хаягдлын төлбөр** /амралтын газар сар бүр – 30.000 төгрөг /

**Хоёр. Захиалагчийн үүрэг:**

2.1.Хог хаягдлын тогтоосон цэгийг хаягжуулан хязгаарлалтыг тогтоосон байх

2.2. Иргэн аж ахуйн нэгж байгууллага орчин газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах

**Гэрээний хугацаа:**

А. Эхлэх: 2023 оны 01 дүгээр сарын 1-ний өдөр

Б. Дуусах: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

**Гурав.** Гэрээ байгуулагч талууд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай 9 дүгээр зүйлд заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.

Гэрээ нь Засаг дарга баталсан өдрөөс эхлэж хүчин төгөлдөр болно.

Гэрээний биелэлтийг талууд жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.

**Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.**

- Аль нэг тал үүргээ биелүүлээгүй бол нэг талын санаачлагаар
- Гэрээ байгуулсан талын аль нэг нь татан буугдсан.

Гэрээний нөхцлийг биелүүлээгүй дутуу биелүүлсэн бол буруутай тал холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ус ашиглуулагчийг төлөөлж:
Төв аймгийн Эрдэнэ сумын
ЗДТГ-ын Байгаль орчны асуудал
хариуцсан мэргэжилтэн
Ц.Ганбаяр
Утас: 94940064

Ус бохирдуулагчийг төлөөлж:
"Хан тэгри мэд" ХХК-ны
хүний нөөцийн менежер
Ж.Аянагүл
Утас: 90990112, 77773336

ХАН ТЭГРИ МЭД
9020011003 6531156
ШТТ8289

Хавсралт 7- Аюултай хог хаягдлын гэрээ

БАТЛАВ:
"ЭЛЕМЕНТ" ХХК ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
....................................
/Б.ЭНХБАДРАЛ/

БАТЛАВ:
"ТЭГРИ МЭД" СУВИЛАЛ
ЗАХИРАЛ
....................................
/........................../

Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх,
Халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээ

№23/124

2023 оны 01..р сарын ..01-ны өдөр Улаанбаатар хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Нэг талаас **"Элемент" ХХК** /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж, санхүү хариуцсан захирал **Б.Энхбадрал,** ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай **А.Энхтуяа** нөгөө талаас **"Тэгри мэд" сувилал** цаашид захиалагч гэх/-ийг төлөөлж ...Оффис менежер... албан тушаалтай ...Б.Мөнх-Эрдэнэ... бид нар харилцан тохиролцож МУ-ын Иргэний хууль, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар" болон ЭМС-ын А/505 тоот тушаал, ЭМС-ын 605 тоот тушаал, байгаль орчны холбогдох хууль, дүрэм журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь эмнэлгээс гарч байгаа аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, халдваргүйжүүлж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

**Хоёр. Захиалагч талын эрх үүрэг**

2.1 Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

2.2 ЭМБ-аас гарч байгаа аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, аюулгүй болгох зааварчилгаа зөрчсөн тохиолдолд шаардлага тавих

2.3 Хог ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, рейсийг бичиж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах

2.4 Хог хаягдал тээвэрлэж устгасны хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх

2.5 Хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход хариуцсан ажилтнаа байгууллага дээрээ байлгаж, хог ачилтанд хяналт тавих

2.6 Гарч байгаа аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын байранд хадгалан хадгалан хүлээлгэн өгөх

2.7 Гүйцэтгэгчийн устгал хийх явцтай танилцаж хяналт тавьж болно.

2.8 Хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө хэмжээг бодитоор хэмжих

**Гурав. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг**

3.1 Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

3.2 Хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах

3.3 Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой байхыг шаардах

3.4 Гэрээний дагуу хог хаягдлаа ачуулаагүй, хог шатаасан, бусад тээврийн хэрэгсэлд дайж явуулсан, ЭМС-ын А/505 тоот тушаалуудыг биелүүлээгүй зөрчсөн, зөрчлийг арилгуулахаар тус тус шаардлага тавьж биелүүлээгүй тохиолдолд хог хаягдлыг татан авахгүй байх эрхтэй.

3.5 Хог хаягдал ачиж тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, захиалагч талын хог хаягдлыг гэрээнд заасан хуваарийн дагуух хугацаанд саадгүй тээвэрлэх

3.6 Эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аваачиж устгах, аюулгүй болгох

3.7 Гүйцэтгэгч талын буруутай үйл ажиллагаанаас тээвэрлэлт саатаж хог хаягдал ихээр, хуримтлагдах, эмгэг хог хаягдал ихээр гарсан тохиолдолд хуваарьт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч гарган тээвэрлэж, халдваргүйжүүлж устгах

3.8 Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй.

## Дөрөв. Тээвэрлэх хугацаа, төлбөр тооцоо

4.1 Үйлчилгээний төлбөрийн зардлыг тусгай зориулалтын эмнэлгийн гаралтай хог хаягдлыг хийх сав, баглаа боодлын үнийг багтаахгүйгээр ЭМС-н А/605 тоот тушаалын аргачлалаар тооцсон дүнгээр сар тутам 65,000 **/Жаран таван мянган/** төгрөгөөр тооцож төлөхөөр тохиролцов.

4.2 Хог хаягдлыг татан авах цаг хугацаа нь сард 1 удаа ачилт хийгдэнэ. Дуудлагын утас: <u>8611-3790</u>

4.3 Үйлчилгээний төлбөрийг /сар, улирал, жил/ бүрийн эхний 10 хоногийн дотор төлнө.

4.4 Эмнэлгээс гарч буй аюултай эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэж, устгана. Тухайн эмнэлгийн гал тогоо, оффис контор, бусад хамааралгүй цэгт үүссэн ахуйн хог хаягдлыг тээвэрлэж устгахгүй. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон эмийн хаягдал, оношлуур зэргийг тусад нь гэрээ хийж тээвэрлэж устгана.

## Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1 Энэхүү гэрээний 4.3-д заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам үнийн дүнгийн 0,2 хувиар алданги тооцож төлнө.

5.2 Захиалагч тал графикт хугацаандаа хог хаягдлаа гаргаж өгөөгүй, машин орж хогийг авах боломжгүй, ЭМС-ын А/505 тоот тушаалыг биелүүлээгүй тохиолдолд Мэргэжлийн хяналтын алба, Халдварт өвчин судлалын үндэсний төвд хандаж, гарсан зөрчлийг арилгуулна.

## Зургаа. Бусад

6.1 Гэрээнд заасан болон бусад зүйлийн талаар маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд эс зөвшөөрвөл шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж гэрээг жил буюу 2023 оны 01-р сарын 01–ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл байгуулав.

6.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож гэрээг дахин шинээр хийнэ.

6.4 Тухайн сар тооцогдсон мөнгөн дүнгийн баримт нь гэрээний салшгүй хэсэг болно. (Устгалд оруулсан тусгай хог хаягдлын хэмжээ, тээвэрлэлтийн бүртгэл зэрэг)

**Долоо. Сунгалт**

7.1 20... оны ... сарын ... өдрөөс 20... оны .... сарын ... өдөр хүртэл сунгалт хийв.

7.2 20... оны ... сарын ... өдрөөс 20... оны .... сарын ... өдөр хүртэл сунгалт хийв.

7.3 20... оны ... сарын ... өдрөөс 20... оны .... сарын ... өдөр хүртэл сунгалт хийв.

**Гэрээ байгуулсан:**

“ЭЛЕМЕНТ” ХХК-ийг төлөөлж
Санхүү хариуцсан захирал
................../Б.Энхбадрал/
Ерөнхий нягтлан бодогч ажилтай
................../А.Энхтуяа/
Санал гомдлын утас: 99107745
Харилцах утас: 86113790, 99193790
Хаяг: Налайх дүүрэг 3-р хороо
Хүчилтөрөгчийн станц гудамж
Харилцах банк: Хаан банк
Харилцах данс: 5007200166

“ТЭГРИ МЭД” СУВИЛАЛ-ийг төлөөлж
..................албан тушаалтай
..................
Утас: ..................
Хаяг: ..................
..................

Хавсралт 8- Хамтран ажиллах гэрээ

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ № 9

Энэхүү гэрээг нэг талаас **ТӨВ АЙМАГ ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА АЮУШИЙН МӨНГӨНБАЯР** /цаашид "сумын Засаг дарга гэх/ нөгөө талаас үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, **"ТЭГРИ МЭД" ХХК** цаашид "иргэн аж ахуйн нэгж" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож **2023 оны 05 дугаар сарын 29-ны өдөр** Төв аймгийн Эрдэнэ суманд байгуулав.

### НЭГ. Гэрээний зорилго

1.1. Энэхүү гэрээ нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа /аж ахуйн нэгж, иргэнтэй/ дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах асуудлаар сумын нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь

- Сум орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт, бүтэн байгуулалтыг дэмжих зорилгоор 5000000 (таван сая) төгрөг сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

### ХОЁР. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд сумын Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлж хэрэгжүүлэх

2.1.2. Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлд тусгагдсан үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл, хөтөлбөр, бага хүүтэй зээлд хамруулах

2.1.3. Бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах, худалдан борлуулах, гадаад, дотоод түншлэлээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

2.1.4. Бизнесийн орчныг дэмжсэн үйл ажиллагааг нэмэгдүүлж, үзэсгэлэн худалдаа, өдөрлөгийг зохион байгуулах

2.1.5. Улс аймгийн шагнал урамшуулалд тодорхойлж, үндэсний болон орон нутгийн арга хэмжээнүүдэд оролцуулах

2.1.6. Үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын тухайн салбарт тавигдах бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт шаардлагыг хангуулахад анхаарч, хяналт тавьж ажиллах

2.1.7. Стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой болоход нь зохион байгуулалтын арга хэмжээ авч гүйцэтгэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагад зуучлах

2.1.8. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах

2.1.9. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх

4.2. Талууд гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлнэ.

**ТАВ. Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа**

5.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ

5.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй нэг хэсэг байна.

5.3. Гэрээг хоёр хувь үйлдэнэ.

ГЭРЭЭГ ЗӨВШӨӨРЧ БАЙГУУЛСАН:

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГА

А.МӨНГӨНБАЯР
88840801

"ТЭГРИ МЭД" ХХК-НЫ
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР

Ж.АЯНАГҮЛ
90990112